

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн,
ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлан

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2017 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН



Харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан төсөл, арга хэмжээний тендерт үнийн санал ирээгүй, ирүүлсэн тендер шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр 60,7 хувийг нь шууд гэрээ байгуулах аргаар, төсөвт өртгөөр нь гүйцэтгүүлсэн байна.

Сүхбаатар сум 2018 он

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа</p> <p>Аудитын менежер Б.Батмөнх</p> <p>Ахлах аудитор С.Баасансүрэн</p> <p>Аудитор Ж.Цогт</p> <p>2018 он</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442 дугаарын утас, Selenge@audit.gov.mn цахим сайтаар харилцана уу.</p> <p>ХАЯГ:Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт</p> <p>Аудитын хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд,</p> <p>А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, тогтоомжид нийцүүлэн, үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?</p> <p>А.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулж, түүний хүрээнд төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан уу?</p> <p>А.2 Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг, төсөв иж бүрэн хийгдэж, хуулийн шаардлага хангасан эсэх ?</p> <p>Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан уу?</p> <p>Б.1 Үнэлгээний хороо, ажлын хэсгийг хууль, журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгосон эсэх?</p> <p>Б.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, тайлагнасан уу?</p> <p>Б.3 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилж, эрх шилжүүлэхдээ хугацаа алдсан эсэх?</p> <p>В. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, санхүүжүүлсэн үү?</p> <p>В.1 Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлсэн үү?</p> <p>В.2 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг холбогдох журам, гэрээний дагуу олгосон уу?</p> <p>В.3 Захиалагч байгууллага гэрээний биелэлтэд тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?</p> <p>Илрүүлсэн зөрчил Дүгнэлт</p> <p>Зөвлөмж Илрүүлсэн зөрчил Дүгнэлт Зөвлөмж</p>
---	--

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?*
- *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан уу?*
- *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, санхүүжүүлсэн үү?*

Хамрах хүрээ:

Аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө, оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийг аймаг, сумдын төсвийн ерөнхийлөн захирагч, ЗДТГ, аймгийн ОНӨГ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнууд, тэдгээрийн худалдан авах ажиллагааны баримт, материалуудыг хамруулан шалгав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан, аймаг, сумдын ЗДТГ, аймгийн Орон нутгийн өмчийн газар, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны санхүүгийн тайлан, мэдээ, шаардлагатай бусад баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль, Барилгын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2016 оны 415 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”, 2013 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Цахим

хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”, 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан *“Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”*, дээрх хууль, журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, холбогдох бусад хууль, эрхийн актуудыг шалгуур болгон ашиглав.

Үндсэн мэдээлэл:

2017 онд Сэлэнгэ аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,486.6 сая төгрөгийн өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдаж, эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн *“Сэлэнгэ аймгийн 2017 оны тодотгосон төсөв батлах тухай”* 33 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх урьд оноос шилжих 16 төсөл, арга хэмжээнд 307.8 сая төгрөгийн, шинээр эхлэх 32 төсөл, арга хэмжээнд 827.9 сая төгрөгийн, их засварын 22 төсөл, арга хэмжээнд 551.7 сая төгрөгийн зэрэг нийт 1,687.5 сая төгрөгийг зарцуулахаар эцэслэн баталснаас 1,664.5 сая төгрөгийн өртөг бүхий 68 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт нар 2018 оны 3 дугаар сарын 26-наас 6 дугаар сарын 5-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

А.1 Төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулж, мөрдөөгүй байна.

1.1 Тус аймаг нь төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, дунд болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, мөрдөөгүйгээс 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулахдаа сумдаас ирүүлсэн санал болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого баримталсан байна. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлээгүй, төсөл арга хэмжээг гол тэргүүлэх чиглэл, ач холбогдолтой уялдуулж эрэмбэлж, төлөвлөөгүй нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 3.6 дахь “ *ТЕЗ, аймаг, нийслэлийн тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол, тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Аймгийн ТЕЗ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны төлөвлөгөөнд тусгуулахаар 83,415.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 27 төсөл, арга хэмжээний саналыг холбогдох яамдад хүргүүлснээс нэг нь ч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй бөгөөд 1,486.6 сая төгрөгийн өртөг бүхий дараах 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдаж, эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1 /сая.төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хуулийн код	Эрх шилжүүлсэн огноо, дугаар	Төсөвт өртөг
1	Эрүүл мэндийн төвийн засвар, А, Б блокийн дээврийн засвар /Сэлэнгэ, Ерөө сум/	XIII.2.19	ЭМ-ийн сайдын 2017.01.23-ны тушаал №А/35	51.0
2	Эрүүл мэндийн төвийн засвар /Сэлэнгэ, Сайхан сум, Номгон тосгон/	XIII.2.18	ЭМ-ийн сайдын 2017.01.23-ны тушаал №А/35	50.0
3	1 дүгээр сургуулийн барилгын дээврийн засвар /Сэлэнгэ, Мандал сум/	X.1.1.3.2	БСШУС-ын сайдын 2017.03.16-ны тушаал №А/89	340.2
4	2 дугаар сургуулийн урлагийн заалны засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	X.1.2.1.1.34	БСШУС-ын сайдын 2017.03.13-ны тушаал №А/82	15.0
5	Цэцэрлэгийн барилгын дотор халаалтын шинэчлэлийн ажил /Сэлэнгэ, Сант сум/	X.1.2.1.1.35	БСШУС-ын сайдын 2017.03.13-ны тушаал №А/82	38.3
6	Сэлэнгийн долгио чуулгын барилгын дээвэр, гадна фасад засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	X.1.2.1.1.36	БСШУС-ын сайдын 2017.03.13-ны тушаал №А/82	86.7
7	Спорт ордоны дээврийн засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, БТСГ/	X.1.2.1.3.5	БСШУС-ын сайдын 2017.03.13-ны тушаал №А/82	89.4
8	2 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	XII.1.2.1.1.116	БСШУС-ын сайдын 2017.05.08-ны 1а/3658 тоот албан бичиг	160.0

9	2 дугаар сургуулийн барилгын засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	XII.1.2.1.1.115	БСШУС-ын сайдын 2017.05.08-ны 1а/3658 тоот албан бичиг	160.0
10	Цэцэрлэгийн барилгын засвар /Сэлэнгэ, Баруунбүрэн сум /	XII.1.2.1.1.118	БСШУС-ын сайдын 2017.05.08-ны 1а/3658 тоот албан бичиг	72.0
11	Соёлын төвийн дээвэр засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	XII.1.2.1.1.119	БСШУС-ын сайдын 2017.05.08-ны 1а/3658 тоот албан бичиг	110.0
12	Багийн төвийн засвар тохижилт /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	III.2.1	ЗГХЭГ-ын даргын 2017.02.17-ны тушаал №55	50.0
13	Сумын ЗДТГ-ын автомашин / Сэлэнгэ, Хушаат сум /	IV.3.1.20	ЗГХЭГ-ын даргын 2017.11.24-ний тушаал №282	35.0
14	Эрүүл мэнд, ниймгийн даатгалын тасгийн барилгын засвар /Сэлэнгэ, Мандал сум/	IX.3.2.1.19	ХНХ-ын сайдын 2017.06.30-ны тушаал №А/117	13.0
15	2 болон 4 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах /Сэлэнгэ, Сүхбаатар сум /	Урсгал зардал	Сангийн сайдын 2017.07.05-ны тушаал №240	50.0
16	4 дүгээр сургуульд зөөврийн компьютер, принтер, тоног төхөөрөмж /Сэлэнгэ, Мандал сум/	Урсгал зардал	Сангийн сайдын 2017.07.05-ны тушаал №240	46.0
17	Мандал, Ерөө сумын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын цахилгаан хангамж /Сэлэнгэ, Мандал, Ерөө сум/	XVI.1.1.2	Эрчим хүчний сайдын 2017.09.07-ны тушаал №120	120.0
Нийт дүн				1,486.6

1.3 Аймгийн хэмжээний хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, дунд болон урт хугацааны төлөвлөгөө боловруулж, мөрдөөгүйгээс 2017 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилга угсралт, их засвар зэрэг бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийг бус урсгал засвар, тоног төхөөрөмж, машин, техник худалдан авах зэрэг цаг үеийн шаардлагатай жижиглэсэн төсөл, арга хэмжээг түлхүү байдлаар тусгаж баталсан нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.

1.4 Аймгийн ИТХ-ын 2016 оны 12-р сарын 02-ны өдрийн “Сэлэнгэ аймгийн 2017 оны төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх төсөл, арга хэмжээг батлаагүй бөгөөд төсвийн жилийн дундуур төсөвт 2 удаа буюу аймгийн ИТХ-ын 2017 оны 5 сарын 5-ны өдийн 21, 2017 оны 11 сарын 14-ний өдрийн 33 дугаар тогтоолуудаар тус тус тодотгол хийж, өмнөх оноос шилжих 16, шинээр эхлэх 54 зэрэг нийт 70 төсөл, арга хэмжээнд 1,687.5 сая / нэг тэрбум зургаан зуун наян долоон сая таван зуун мянга / төгрөгийн санхүүжилт олгохоор эцэслэн баталсан байна. / Хавсралт 1-д харуулав /

1.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2- т заасны дагуу аймгийн дараа оны төсвийг өмнөх оны 12 сарын 05-наас өмнө батлахдаа хөрөнгө, санхүүгийн нөөц боломжоо бүрэн гүйцэт, бодитоор тооцоогүйгээс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг төлөвлөхгүйгээр тайлант он гарсан хойно буюу он дуусахаас сар гаруйхан хугацааны өмнө тодотголоор нэмэлт хийн, төлөвлөж байгаа нь тухайн жилийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, улмаар гүйцэтгэл, хэрэгжилтийн ажлууд оройтож, холбогдох хууль, тогтоомж зөрчигдөх, хийгдсэн ажлууд чанарын шаардлага хангахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

1.6 Хамгийн сүүлд буюу 2017 оны 11 сарын 14-нд баталсан төсвийн тодотголоор 140,4 сая төгрөгийн өртөг бүхий дараах 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нэмж төлөвлөсөн байна. Үүнд:

- *Аймгийн Татварын хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах 25,0 сая төгрөгийн,*
- *Алтанбулаг сумын 64 айлын орон сууцанд халаах хэрэгсэл тавих 52,0 сая төгрөгийн,*
- *Цагааннуур сумын трансформатар засварын 7,2 сая төгрөгийн,*
- *Хилийн цэргийн 101 дүгээр ангийн урсгал засварын 9,6 сая төгрөгийн,*
- *Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ-ын мах хадгалах зоорины хөргөлтийн тоног, төхөөрөмжийн засвар, шинэчлэлтийн 13,0 сая төгрөгийн,*
- *Шинэ худалдааны төвийн агааржуулалт, кондейшн тавих 13,0 сая төгрөгийн,*
- *Сүхбаатар сумын уурын зуухны яндан буулгах 3,0 сая төгрөгийн,*
- *Шаамар суманд зөгийн өвөлжөө байгуулах 17,6 сая төгрөгийн зэрэг болно.*

1.7 Он дуусахаас сар гаруйхан хугацааны өмнө нэмж төлөвлөгдсөн дээрх төсөл, арга хэмжээнээс Шаамар сумын зөгийн өвөлжөө байгуулах, Алтанбулаг сумын 64 айлын нийтийн орон сууцанд халаах хэрэгсэл тавих, Хилийн цэргийн 101 дүгээр ангийн урсгал засвар, Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ-ын мах хадгалах зоорины хөргөлтийн тоног, төхөөрөмжийн засвар, шинэчлэлтийн, шинэ худалдааны төвийн агааржуулалт, кондейшн тавих ажлуудыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдахаас өмнө хийж гүйцэтгэсэн буюу өөрөөр хэлбэл ажил хийгдсэний дараа санхүүжилтийг нь төлөвлөсөнтэй холбоотойгоор худалдан авах ажиллагааны баримтуудыг төсөв батлагдсан хугацаанд нь тохируулан хуурамчаар бүрдүүлсэн байна.

1.8 Аймгийн Татварын хэлтэст тоног, төхөөрөмж худалдан авах 25,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь оройтож, тоног төхөөрөмжийг он гарсны дараа нийлүүлсэн байхад хүлээн авсан актыг 2017 оны 12-р сарын 22-нд хуурамчаар бүрдүүлсэн байна.

А.2 ТЭЗҮ, зураг, төсөв иж бүрэн хийгдээгүй болон улсын төсөвт байгууллагуудад хийгдэх төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, батлуулсан зэргээр холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн байна.

2.1 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “*Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана*” гэж заасан байдаг.

2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлж буй төсөл, арга хэмжээ нь төсөвт тусгагдаж, батлагдах эсэх нь тодорхой бус байдаг, зураг, төсвийг урьдчилан хийлгэх санхүүжилт байхгүй гэдэг шалтгаанаар санал хүргүүлсэн 27 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээний зураг, төсөв хийгдсэн бол 24 төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг, төсөв хийгдээгүй байна.

2.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан 17 төсөл, арга хэмжээнээс 16 /*Хушаат сумын ЗДТГ-т автомашин худалдан авахад зураг, төсвийн шаардлагагүй*/ төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төлөвлөхийн өмнө бус батлагдсан төсөвт өртөгт нь багтааж, батлагдсаны дараа нь гүйцэтгүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Зураг, төсөв хийсэн компани, төсөвчин	Зураг, төсөв хүлээлцсэн актын огноо
1	Ерөө сумын ЭМТ-ийн засвар, А.Б блокийн дээврийн засвар	51.0	Арлын ам ХХК Ч.Рашаандаваа	Зураг төсөв хүлээлцсэн актгүй
2	Сайхан сумын Номгон тосгоны ЭМТ-ийн засвар	50.0	Талхун-Арал ХХК Ж.Жамбалдорж	Зураг төсөв хүлээлцсэн актгүй
3	Мандал сумын 1-р сургуулийн дээврийн засвар	340.2	Талхун-Арал ХХК Ж.Жамбалдорж	Зураг төсөв хүлээлцсэн актгүй
4	Сүхбаатар сумын 2-р сургуулийн урлагийн заалны засвар	15.0	Талхун-Арал ХХК Ц.Цогжавхлан	2017.03.22-ны актаар
5	Сант сумын цэцэрлэгийн барилгын дотор халаалтын шинэчлэлтийн ажил	38.3	Бурхант-Орд ХХК Д.Солонго	2017.04.20-ны актаар
6	Сэлэнгийн долгио чуулгын барилгын дээвэр, гадна фасад засвар	86.7	Талхун-Арал ХХК Ж.Жамбалдорж	2017.03.17-ны актаар
7	Аймгийн БТСГ-ын дээврийн засвар	89.4	Талхун-Арал ХХК Ж.Жамбалдорж	2017.03.30-ны актаар
8	Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн барилгын их засвар	160.0	Талхун-Арал ХХК Ж.Жамбалдорж	Зураг төсөв хүлээлцсэн актгүй
9	Сүхбаатар сумын 2-р сургуулийн барилгын засвар	160.0	Талхун-Арал ХХК Ц.Цогжавхлан	2017.03.23-ны актаар
10	Баруунбүрэн сумын цэцэрлэгийн засвар	72.0	Талхун-Арал ХХК Ж.Жамбалдорж	2017.03.17-ны актаар
11	Сайхан сумын Соёлын ордны дээврийн засвар	110.0	Талхун-Арал ХХК Ж.Жамбалдорж	2017.03.20-ны актаар
12	Сүхбаатар сумын багийн төвийн засвар, тохижилт	50.0	Талхун-Арал ХХК З.Энхжаргал	2017.05.17-ны актаар
13	Мандал сумын ЭМНД-ын тасгийн барилгын засвар	13.0	П.Төмөрбаатар Мэргэшсэн төсөвчин	Зураг төсөв хүлээлцсэн актгүй
14	Сүхбаатар сумын 2 болон 4 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах	50.0	Талхун-Арал ХХК З.Энхжаргал	Зураг төсөв хүлээлцсэн актгүй
15	Мандал сумын 4-р сургуульд зөөврийн компьютер, принтер, тоног төхөөрөмж авах	46.0	Төсөв батлагдсаны дараа тооцоо хийсэн	
16	Ерөө, Мандал сумын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж	120.0	Ё.Лхүндэв-Тэргүүлэх төсөвчин, Л.Алтанчимэг- Мэргэшсэн төсөвчин	Зураг төсөв хүлээлцсэн актгүй

Захиалагч аймгийн ЗДТГ нь дээрх төсөл, арга хэмжээнээс 2 барилга, байгууламжийн зураг, төсвийг тусгай зөвшөөрөл бүхий зураг, төсвийн компанид харьяалагддаггүй, зөвхөн төсөвчний тамга, тэмдэгтэй П.Төмөрбаатар, Ё.Лхүндэв, Л.Алтанчимэг зэрэг иргэдээр гүйцэтгүүлсэн байгаа нь Барилгын тухай хуулийн 14.1¹, 17.1² дэх заалтуудыг зөрчсөн байна.

¹ Барилга байгууламжийн зураг төсөл, барилгын ажил, материал үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

² Зураг төсөл зохиогч нь Иргэний хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй: 17.1.1. тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зураг төсөл боловсруулах ажил, үйлчилгээ эрхлэх.

2017 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр хэрэгжүүлэхээр тусгагдсан нийт 54 төсөл, арга хэмжээний 53.7 хувь буюу 764,2 сая төгрөгийн өртөг бүхий 29 төсөл, арга хэмжээг ТЭЗҮ, зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр төлөвлөсөн байна. / Хавсралт 2-т харуулав /

2.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны төлөвлөгөөнд улсын төсөвт байгууллагуудын урсгал засвар болон хөрөнгө худалдан авахад нийт 104,3 сая төгрөгийг төлөвлөж хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь ” Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “ гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- ❖ Алтанбулаг дахь гаалийн шалган нэвтрүүлэх байрны нийтийн бие засах өрөөний засвар 40.0 сая төгрөг,
- ❖ Аймгийн Татварын хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах 25.0 сая төгрөг,
- ❖ Хилийн цэргийн 0101-р ангийн урсгал засвар 9.5 сая төгрөг,
- ❖ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны уулзалтын өрөөг тохижуулах 5.0 сая төгрөг,
- ❖ Аймгийн Прокурорын газарт архивын шүүгээ худалдан авах 4.8 сая төгрөг,
- ❖ Хүнс, хөдөө аж ахуйн газарт автомашин авах 18,0 сая төгрөг,
- ❖ Статистикийн хэлтсийн автомашины засвар 2,0 сая төгрөг,

2.5 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны батлагдсан төлөвлөгөөнөөс харахад тайлант онд шинээр эхлэх нийт 54 төсөл, арга хэмжээний 53-ынх нь өртгийг нээлттэй тендер шалгаруулалтаар бус шууд болон харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах босго үнэнд багтаан төлөвлөсөн бөгөөд нэгтгэж, нэг багц болгон төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой дараах төсөл, арга хэмжээг салгаж төлөвлөсөн байдал ажиглагдаж байна. Үүнд:

- ❖ Сүхбаатар сумын 7-р багийн төмөр замын байруудыг халуун усаар хангах зуух угсрах 80.0 сая төгрөгийн , дулаан хуваарилах төвийн засварын 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлууд,
- ❖ Жавхланта сумын цэнгэлдэх хүрээлэн барих 80.0 сая төгрөгийн, морь барианы газар байгуулах 10.0 сая төгрөгийн ажлууд,
- ❖ Хушаат сумын цэнгэлдэх хүрээлэн барих 80.0 сая төгрөгийн, морь барианы газар байгуулах 10.0 сая төгрөгийн ажлууд,
- ❖ Сүхбаатар сумын 7-р багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах 20,0 сая төгрөгийн , 6-р багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах 20,0 сая төгрөгийн, 5-р багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах 20,0 сая төгрөгийн ажлууд гэх мэт

2.6 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулалтын шинж чанартай бус тухайн байгууллагын урсгал зардалд тусган, хэрэгжүүлэх боломжтой дараах төсөл, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлсэн нь хөрөнгө оруулалтын зардлын үр нөлөөг бууруулснаас гадна Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх “ Хөрөнгө оруулалт гэж, тухайн байгууллагын өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- ❖ Дулаанхан тосгоны Захирагчийн албаны барилгын зураг, төсвийн үнэ 10,0 сая төгрөг,
- ❖ Сүхбаатар сумын уурын зуухны яндан буулгах 3,0 сая төгрөг,
- ❖ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны уулзалтын өрөөг тохижуулах 5,0 сая төгрөг,
- ❖ Сүхбаатар сумын 4-р цэцэрлэгт зөөлөн эдлэл авах 5,0 сая төгрөг,
- ❖ Сүхбаатар суманд хогийн бункер авах 6,0 сая төгрөг,
- ❖ Сүхбаатар суманд хог хураамжийн бүртгэл, тооцооны програм авах 2,4 сая төгрөг
- ❖ Сүхбаатар самбарын засвар 5,0 сая төгрөг гэх мэт

**Б.1 Худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулах
“Ажлын хэсэг”-т 3-5 хүнийг тогтмол томилон ажиллуулж байгаа нь
ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг дагуулж байна.**

1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 17 төсөл, арга хэмжээнээс аймгийн ОНӨГ 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын, 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар, Мандал сум 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан байна.

1.2 Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 70 төсөл, арга хэмжээнээс 68-г нь хэрэгжүүлсэн бөгөөд 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын, 46 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 21 төсөл арга хэмжээг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

1.3 Орон нутгийн төсвөөр хэрэгжсэн бөгөөд гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан нийт 46 төсөл, арга хэмжээнээс 16 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг аймгийн ОНӨГ, 28 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг Алтанбулаг, Баруунбүрэн, Ерөө, Жавхлант, Зүүнбүрэн, Шаамар, Цагааннуур, Түшиг, Сант, Сайхан, Сүхбаатар, Орхонтуул, Хушаат зэрэг 13 сум, 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг “Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ сонгон шалгаруулж хэрэгжүүлсэн байна. / *Хавсралт 3-т харуулав.* /

1.4 Шаамар сум нь эрх шилжсэн “Зөөврийн тайз, хөгжим худалдан авах” 20,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар зохион байгуулалгүйгээр “Буянт мөрөн аривжих” компаниас шууд худалдан авсан байна.

1.5 Орон нутгийн төсвөөр хэрэгжиж, шууд худалдан авсан 21 төсөл, арга хэмжээнээс аймгийн ЗДТГ 6-г нь хэрэгжүүлсэн бол Сүхбаатар суманд 7, Шаамар, Хушаат сумдад тус бүр 2, Жавхлант, Орхонтуул, Цагааннуур сумд, Хилийн цэргийн 101 дүгээр ангид тус бүр 1 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн байна. / *Хавсралт 4-т харуулав.* /

1.6 Худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулах улсын төсвийн 7, орон нутгийн төсвийн 1 зэрэг нийт 8 төсөл, арга хэмжээний “Үнэлгээний хороо”-г аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар тус бүр 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

1.7 Гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг аймгийн ОНӨГ зохион байгуулсан улсын төсвийн 9, орон нутгийн төсвийн 16 зэрэг нийт 25 төсөл, арга хэмжээний “Ажлын хэсэг” –ийг тус газрын даргын тушаалаар байгуулсан байна.

1.8 Дээрх “Ажлын хэсэг”-ийг тус бүр 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд ОНӨГ-ын ахлах мэргэжилтэн Д.Октябрийг ажлын хэсгийн даргаар 25 удаа, гишүүнээр мэргэжилтэн Д.Ариунтуулыг 20 удаа, мэргэжилтэн Х.Нэргүйбаатарыг 22 удаа томилсон бол аймгийн ЗДТГ-ын ахлах мэргэжилтэн П.Ган-Очир, мэргэжилтэн Б.Отгонбаасан, Д.Хишигбат, Газрын харилцаа хот байгуулалтын газрын мэргэжилтэн н.Доржмягмар нарыг тус бүр 1 удаа томилсон байна.

1.9 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих, 10,0-80,0 сая төгрөгийн өртөг бүхий 25 худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулах “Ажлын хэсэг”-ийг 3 хүний бүрэлдэхүүнтэй, ялангуяа 1 хүнийг бүх ажлын хэсгийн даргаар, 2 хүнийг 20-22 ажлын гишүүнээр явцуу хүрээнд давхардуулан томилон ажиллуулж байгаа нь ашиг сонирхолын зөрчил үүсэх эрсдэлийг дагуулж байна.

1.10 Сумдад эрх шилжсэн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулах “Ажлын хэсэг”-ийг сумын ЗДТГ-ын даргын тушаалаар 3-7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

1.11 Хушаат сумын ЗДТГ-ын дарга нь ажлын хэсгийг нарийн бичгийн даргагүй, 8 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байгаа нь Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан “*Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам*”-ын 2.1³, 2.3⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

1.12 Сүхбаатар сум нь эрх шилжүүлсэн 16 төсөл, арга хэмжээнээс 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа ажлын хэсгийн даргаар сумын Засаг даргын орлогч М.Тэмүүлэнг 9 удаа, нарийн бичгийн даргаар сумын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн Ж.Уянгыг 9 удаа, гишүүдээр эдийн засагч-статистикч Г.Золбоог 9, Тохижилт үйлчилгээний газрын дарга Ц.Насантогтохыг 8 удаа гэх мэтчилэн 5 хүнийг тогтмол ажиллуулсан байна.

1.13 Сүхбаатараас бусад эрх шилжсэн 12 сумын харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт томилогдсон 57 гишүүнээс худалдан авах ажиллагаанд мэргэшсэн, АЗ сертификат бүхий 5-хан гишүүн байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.6⁵ дахь заалтыг зөрчсөнөөс гадна худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

1.14 Баруунбүрэн, Сант, Сайхан, Орхонтуул, Түшиг, Шаамар сумдууд нь харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Ажлын хэсэг”-ийг сумын Засаг даргын захирамжаар томилсон байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 45.3⁶ дахь заалтыг зөрчсөн байна.

Б.2 Сумдууд худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа зарим тендерт 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал хүргүүлээгүй бөгөөд үнэлгээний хуудсаар үнэлж баримтжуулаагүй байна.

2.1 Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн бөгөөд НТШ-ын болон харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан 33 төсөл, арга хэмжээнээс 27 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр, 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цаасан хэлбэрээр зохион байгуулсан байна.

2.2 Сүхбаатар суманд эрх шилжсэн бөгөөд шууд худалдан авалтын босго үнээс давсан 9 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион

³ Үнэлгээний хорооны гишүүд нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн бүрэлдэхүүнтэй байна....

⁴ Үнэлгээний хороо нь сондгой тооны гишүүдтэй байна.

⁵ Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

⁶ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.

байгуулахдаа “Сүхбаатар сумын барилгын 27-р байрыг хэрэглээний халуун усны шугамд холбох”, “Сүхбаатар сумын 1-р сургуулийн дотуур байрны засвар” –ын ажил зэрэг нийт 40,0 сая төгрөгийн өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээнд шаардлага хангасан 3 буюу түүнээс дээш эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй байна.

2.3 Бусад 12 суманд эрх шилжсэн бөгөөд шууд худалдан авалтын босго үнээс давсан 19 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа 234,0 сая төгрөгийн өртөг бүхий дараах 9 төсөл, арга хэмжээнд шаардлага хангасан 3 буюу түүнээс дээш эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

				<i>Хүснэгт 3</i>
Д/д	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг / сая төг /	Тайлбар	Шууд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж
1	Зүүнбүрэн сумын сургуульд мэдээлэл зүйн кабинет байгуулах	20.0	Эрх бүхий 3-н этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй.	Мөнхийн баярт од ХХК
2	Шаамар сумын шинэ цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулж, хашаа барих	27.0	Эрх бүхий 3 бус 2 этгээдэд үнийн санал хүргүүлсэн. / Наранбулаг ХХК, Хас жинст ХХК/	Наранбулаг ХХК
3	Орхонтуул сумын Рашаант тосгоны 2 дугаар сургуулийн тоног төхөөрөмж шинэчлэлт	26.6	Эрх бүхий 3-н этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй.	Визарт экспресс консалтинг ХХК
4	Орхонтуул сумын Рашаант эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	20.0	Эрх бүхий 3-н этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй.	Санни Гоулд Хаус ХХК
5	Баруунбүрэн сумын сургуулийн дотуур байрны барилгын засвар	20.0	Эрх бүхий 3-н этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй.	Шинэ эрдэнэт констракшн ХХК
6	Шаамар сумын 18-р цэцэрлэгийн хашаа барих	20.0	Эрх бүхий 3 бус 2 этгээдэд үнийн санал хүргүүлсэн. / Наранбулаг ХХК, Хас жинст ХХК/	Наранбулаг ХХК
7	Шаамар суманд зөгийн өвөлжөө байгуулах	17.6	Эрх бүхий 3-н этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй.	Ханлигтайшир ХХК
8	Алтанбулаг сумын 64 айлын нийтийн орон сууцанд халаах хэрэгсэл тавих	52.8	Эрх бүхий 3-н этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй.	Сэлэнгэ-Энерго ХХК
9	Орхонтуул сумын Засаг дарга автомашин авах	30.0	Эрх бүхий 3-н этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй.	Иргэн Э.Болор-Эрдэнэ
10	Нийт дүн	234,0		

2.4 Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа шаардлага хангасан 3 ба түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй байгаа нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 33.2 дахь “ Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ “, 33.2.1 дэх “ *Техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх*” гэсэн заалтыг зөрчиж, үнийн харьцуулалтын аргын утга, учрыг алдагдуулж байна.

2.5 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн бөгөөд худалдан авах ажиллагааны харьцуулалтын аргыг хэрэглэсэн нийт 56 төсөл, арга хэмжээнээс / аймгийн ОНӨГ 25, Сүхбаатар сум 9, Мандал сум 1, бусад сумд 19, Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ 2 / 864,3 сая төгрөгийн өртөг бүхий 28 төсөл, арга хэмжээнд нэг ч үнийн санал ирээгүй, 223,8 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээнд материалын бүрдэл дутуу, тендерийн

шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр “ Ажлын хэсэг “ шууд гэрээ байгуулах мэдэгдлийг аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн байна. Эдгээрийг Хүснэгт 4,5- д дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт 4

Нэг ч үнийн санал ирээгүйгээс шууд гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээ

/ ОНАГ-ын зохион байгуулсан /

Д/д	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг / сая төг /	Шууд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж
1	Хушаат сумын ЗДТГ-т авто машин авах /УТХО /	35,0	Мэргэн анд ХХК
2	Мандал сумын ЭМНД-ын тасгийн барилгын засвар / УТХО/	13,0	Сэлэнгэ таван хан ХХК
3	Сүхбаатар сумын 3-н замын уулзвар, атарчдын дурсгалын хөшөө босгох / ОНХО /	50.0	Сэлэнгэ таван хан ХХК
4	Цэнхэрийн 19, 20-р байрны гадна тохижилт, зам өргөтгөх / ОНХО /	40.0	Сэлэнгэ АЗЗА ТӨХК
5	Сүхбаатар сумын 4-н багт ухаалаг худгийн тоног төхөөрөмж суурилуулах / ОНХО /	48.0	Эйч ти эл ХХК
6	Биеийн тамир спортын газрын барилгын их засвар / ОНХО /	50.0	Дэлгэр ган ХХК
7	Баруунбүрэн сумын эмнэлгийн засвар	30.0	Талхун арал ХХК
8	Сүхбаатар сумын 4-р сургуулийн спорт заалны засвар / ОНХО /	30.0	Сүлд ханба ХХК
9	Сүхбаатар сумын Спорт сургуулийн сантехник засвар / ОНХО /	20.0	Сүлд ханба ХХК
10	Хилийн цэргийн 0243-р ангид моторт завь худалдан авах /ОНХО /	25.0	Шар нарст ХХК
11	Усан спортын төвд хүүхдийн сургалтын зам худалдан авах/ ОНХО/	18.0	Монтир транс ХХК
12	Сэлэнгийн долгио чуулгад тайзны гэрэлтүүлэг авах / ОНХО /	47.3	Хараат богд ХХК
13	Хүнс, хөдөө аж ахуйн газарт автомашин авах / ОНХО /	18.0	Нарт оргил өргөө ХХК
14	Татварын хэлтэст тоног төхөөрөмж авах / ОНХО /	25.0	Хөтөл төвхөн ХХК
15	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт засвар, автомашины засвар/ОНХО/	27.1	Хүчит сэлэнгэ ХХК
16	Сайхан сумын Засаг даргын Тамгын газрын барилгын дээврийн их засвар / ОНХО /	73.9	Хүчит номин констракшн ХХК
17	Алтанбулаг гаалийн шалган нэвтрүүлэх байрны нийтийн бие засах ерөөний тохижилт / ОНХО /	40.0	Экструд констракшн ХХК

Сумдад эрх шилжсэн:

1	Зүүнбүрэн сумын сургуульд мэдээлэл зүйн кабинет байгуулах	20.0	Мөнхийн баярт од ХХК
2	Шаамар сумын шинэ цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулж, хашаа барих	27.0	Наранбулаг ХХК

3	Орхонтуул сумын Рашаант тосгоны 2 дугаар сургуулийн тоног төхөөрөмж шинэчлэлт	26.6	Визарт экспресс консалтинг ХХК
4	Орхонтуул сумын Рашаант эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	20.0	Санни Гоулд Хаус ХХК
5	Баруунбүрэн сумын сургуулийн дотуур байрны барилгын засвар	20.0	Шинэ эрдэнэт констракшн ХХК
6	Шаамар сумын 18-р цэцэрлэгийн хашаа барих	20.0	Наранбулаг ХХК
7	Шаамар суманд зөгийн өвөлжөө байгуулах	17.6	Ханлигтайшир ХХК
8	Алтанбулаг сумын 64 айлын нийтийн орон сууцанд халаах хэрэгсэл тавих	52.8	Сэлэнгэ-Энерго ХХК
9	Орхонтуул сумын Засаг дарга автомашин авах	30.0	Иргэн Э.Болор-Эрдэнэ
10	Сүхбаатар сумын барилгын 27-р байрыг хэрэглээний халуун усны шугамд холбох	20,0	Сүлд ханба ХХК
11	Сүхбаатар сумын 1-р сургуулийн дотуур байрны засвар	20,0	Есөн хэлхээ ХХК
	Нийт дүн	864,3	

Хүснэгт 5

Тендерийн шаардлага хангаагүйгээс шууд гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээ

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг / сая төг /	Тайлбар	Шууд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж
1	Сүхбаатар суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах	50.0	Ноён тойром ХХК тендерийн шаардлага хангаагүй	Нарт оргил өргөө ХХК
2	Шаамар сумын шинэ цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулж, хашаа барих	27.0	Путьс, Цэгц нум, Наранбулаг, Квом ХХК-дад урилга хүргүүлсэн. Хас жинст ХХК, Наранбулаг ХХК-аас үнийн санал ирүүлсэн боловч шаардлага хангаагүй.	Наранбулаг ХХК
3	Сант сумын сургуулийн зааланд тоног төхөөрөмж авах	20.0	Элжи констракшн, Хай Тэч Хаус ХХК-иас ирүүлсэн тендер шаардлага хангаагүй.	Элжи констракшн ХХК
4	Сайхан суманд ус зөөлрүүлэх төхөөрөмж тавих	26.8	Сайхан төгөл, Байгал ус ХХК-ийн ирүүлсэн тендер шаардлага хангаагүй.	Ирмүүн бармат ХХК
5	Жавхлант суманд цэнгэлдэх хүрээлэн барих	80.0	Бурхант орд ХХК-иас ирүүлсэн тендер шаардлага хангаагүй.	Ахмед интершнл ХХК
6	Шаамар сумын 18-р цэцэрлэгийн хашаа барих	20.0	Путьс, Цэгц нум, Наранбулаг, Квом ХХК-дад урилга илгээсэн. Хас жинст ХХК, Наранбулаг ХХК-аас үнийн санал ирүүлсэн боловч шаардлага хангаагүй.	Наранбулаг ХХК
	Нийт дүн	223,8		

2.6 Дээр дурдсанчлан улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн бөгөөд харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ёстой нийт 56 төсөл, арга хэмжээний 34-ынх нь буюу 60,7 хувийнх нь худалдан авах ажиллагааг үнийн санал ирүүлээгүй, тендерийн шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсэн нь төсөл, арга хэмжээний зураг, төсвийг хийлгүйгээр багцаагаар баталдаг, худалдан авах ажиллагааны зохион байгуулалт муу, ижил, төстэй ажил гүйцэтгэсэн, шаардлага хангасан аж ахуйн нэгжийн судалгаа, сан байдаггүй, үнийн санал авах мэдэгдлийг шаардлага хангасан 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд хүргүүлдэггүй зэргээс шалтгаалсан гэж үзэж байна.

2.7 Худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлснээр үнийн харьцуулалт хийж, хамгийн бага үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгжийг сонгох зарчим алдагдан, харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан орон нутгийн төсвийн 46 төсөл арга хэмжээний 26-г нь, үүний дотор аймгийн ОНӨГ-ын зохион байгуулсан орон нутгийн төсвийн 16 төсөл, арга хэмжээний 10-ыг нь батлагдсан төсөвт өртгөөр нь гүйцэтгүүлсэн байна. / *Хавсралт 5-д харуулав* /

2.8 Сүхбаатар сумын худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулах “Ажлын хэсэг” нь орон нутгийн төсвөөр хэрэгжсэн 235,0 сая төгрөгийн өртөг бүхий дараах 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хуудсаар үнэлсэн нотлох баримтыг бүрдүүлэн, “ Ажлын хэсэг”-ийн хуралд танилцуулж, шийдвэр гаргаагүй байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 12.1 дэх “Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавхи болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлана” гэсэн заалтыг зөрчсөнөөс гадна эдгээр ажлуудын гүйцэтгэгчийг хуулийн дагуу үнэн, шударгаар сонгон шалгаруулахгүй байх эрсдэлийг үүсгэж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6

Д/д	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг /сая.төг/	Гүйцэтгэгч аж ахуйн нэгж
1	Сүхбаатар сумын 5-р багт тоглоомын талбай байгуулах	20.0	Бор гүвээ бүлэг
2	Сүхбаатар сумын шарын 11,12,13-р байрны дунд тоглоомын талбай байгуулах	20.0	Таван хан уул ХХК
3	Сүхбаатар сумын 7-р баг төмөр замын байруудыг хэрэглээний халуун усаар хангах зорилгоор зуух угсрах	80.0	Эко партнерс ХХК
4	Сүхбаатар сумын 7-р багийн дулаан хуваарилах төвийн засвар	20.0	Эко партнерс ХХК
5	Гэрэлт хөшөөний засварын ажил, нийтийн бие засах газар барих	40.0	Таван хан уул ХХК
6	Сэлэнгийн долгио чуулгын гадна террас өргөтгөх	35.0	Хүчит сэлэнгэ ХХК
7	Сүхбаатар сумын 7-р багийн 60 айлын дунд тоглоомын талбай байгуулах	20.0	Таван хан уул ХХК
	Нийт дүн	235,0	

2.9 Гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг аймгийн ОНӨГ-аас зохион байгуулсан төсөл, арга хэмжээнд оршиж буй гол зөрчлүүдээс жишээ болгон дурдвал:

1. Үнийн санал ирүүлсэн компани байхгүй учир, хэн нэгний санал болгосон гэдэг шалтгаанаар шууд гэрээ байгуулсан:

- 27,0 сая төгрөгийн өртөг бүхий аймгийн нэгдсэн эмнэлгийн засвар, автомашины засварын ажлыг эмнэлгийн даргын санал болгосон гэдэг үндэслэлээр Хүчит сэлэнгэ компанитай шууд гэрээ байгуулж, төсөвт өртгөөр нь,
- 25,0 сая төгрөгийн өртөг бүхий моторт завь худалдан авах ажлыг Хилийн цэргийн 0243 дугаар ангийн захирагч санал болгосон гэдэг үндэслэлээр Шар нарст компанитай шууд гэрээ байгуулж, төсөвт өртгөөр нь,
- 18,0 сая төгрөгийн өртөг бүхий усан бассейнд сургалтын зам худалдан авах ажлыг БТСГ-ын нягтлан бодогч санал болгосон гэдэг үндэслэлээр Дэлгэр ган компанитай шууд гэрээ байгуулж, төсөвт өртгөөр нь,
- 18,0 сая төгрөгийн өртөг бүхий аймгийн ХХААГ-т авто машин худалдан авах ажлыг тус газрын дарга санал болгосон гэдэг үндэслэлээр Нарт-оргил компанитай шууд гэрээ байгуулж, төсөвт өртгөөр нь,
- 25,0 сая төгрөгийн өртөг бүхий Татварын хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг уг ажилд оролцоно гээд тоон гарын үсэг аваад явсан гэх үндэслэлээр Хөтөл төвхөн ХХК-тай шууд гэрээ байгуулан, батлагдсан төсөвт өртгөөр нь гүйцэтгүүлсэн байна.

2. Хамгийн бага үнийн санал ирүүлсэн компани шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр тендерээс татгалзаж, төсөвт өртгөөр нь шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсэн:

- *50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах” ажлын гүйцэтгэгчийг сонгохдоо сэлбээгийн үнийг оруулж тооцоогүй гэх шалтгаанаар хамгийн бага / 45,0 сая төгрөг / үнийн санал ирүүлсэн “Ноён тойром” ХХК-ийн тендерээс татгалзаж, Сэлэнгэ-үйлчилгээ үйлдвэрийн газрын даргын санал болгосон гэх үндэслэлээр барилгын засвар, засал чимэглэл, барилгын материалын худалдаа эрхлэх үйл ажиллагааны чиглэл бүхий Нарт оргил өргөө компанитай шууд гэрээ байгуулж, төсөвт өртгөөр нь,*
- *73,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сайхан сумын ЗДТГ-ын барилгын дээврийн их засварын ажлыг гүйцэтгэхээр хамгийн бага буюу 70,0 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн Талст-Өргөө компанийг “ Зохиогчийн хяналтын зардлыг тооцоогүй” гэдэг үндэслэлээр тендерээс татгалзсан тухай мэдэгдийг 2016 оны 6 сарын 15-ны өдрийн 179 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна. Харин Талст-Өргөө компани “ Зохиогчийн хяналтын зардал 634,2 мянган төгрөгийг төсвийн нэгдсэн товчоонд бусад нэмэлт зардал гэсэн нэртэйгээр тусгасан болно” гэсэн хариуг 2017 оны 6 сарын 16-ны өдрийн 93 дугаар албан бичгээр ирүүлсэн, шууд гэрээ байгуулах үнийн санал ирүүлэх урилгыг 2017 оны 6 сарын 26-ны өдрийн 191 дүгээр албан бичгээр буюу тухайн компани тайлбар ирүүлсний дараа Хүчит номин констракшн компанид хүргүүлсэн атал Талст-Өргөө компанид 2017 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 182 дугаар албан бичгээр “ Хуулийн 54.7-д заасан үндэслэлээр гэрээ байгуулах эрх олгосноос хойш ирсэн гомдлыг*

захиалагч хүлээн авахгүй” гэдэг хариу хүргүүлж, тендерээс татгалзсан нь цаг хугацааны хувьд зөрчилдөж байна.

Дээрх үндэслэлээр Талст-Өргөө компанийн тендерээс татгалзаж уг ажлыг үнийн санал ирүүлээгүй Хүчит номин констракшн компанитай “Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс дээр гэрээ байгуулах хүсэлтэй байна гэсэн санал тавьж очсон, манай байгууллага дээр материалаа барьж ирсэн” гэдэг үндэслэлээр шууд гэрээ байгуулан батлагдсан төсөвт өртөг болох 73,9 сая төгрөгөөр нь,

- *50,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Биеийн тамир спортын газрын барилгын их засварын ажлыг гүйцэтгэхээр Дэлгэр ган компани ганцаараа 48,5 сая төгрөгийн үнийн санал ирүүлснийг шаардлага хангаагүй гэж тендерээс татгалзсан атал шууд гэрээ байгуулах санал хүргүүлж, ирсэн саналаас нь 1,3 сая төгрөгөөр илүү буюу 49,8 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.*

Дээрхээс гадна 30,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн заалны засварын ажилд ганцаараа 29,8 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн гэж Сүлд хамба компанид 2017 оны 6 сарын 13-нд тендерийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хүргүүлсэн бол 20,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Спорт сургуулийн сантехник засварын ажилд мөн ганцаараа 19,8 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн гэж тус компанид 6 дугаар сарын 13-нд мэдэгдэл хүргүүлж, нэг компанийг 2 ажлын гүйцэтгэгчээр цаг хугацааны хувьд давхардуулан сонгон шалгаруулсан нь төлөвлөсөн ажлуудыг цаг хугацаанд нь гүйцэтгэхгүй байх, хийгдсэн ажлууд чанарын шаардлага хангахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

2.10 Гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг Сүхбаатар сумаас зохион байгуулсан төсөл, арга хэмжээнд оршиж буй гол зөрчлүүдээс жишээ болгон дурдвал:

- *80,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сүхбаатар сумын төмөр замын байруудыг хэрэглээний халуун усаар хангах уурын зуух угсрах болон 20,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сүхбаатар сумын 7 дугаар багийн дулаан хуваарилах төвийн ажлын гүйцэтгэгчээр тусгай зөвшөөрлийн хугацаа нь 2014 оны 6 сарын 14-нд дууссан Эко партнерс компанийг сонгон шалгаруулж, гүйцэтгүүлсэн байна.*
- *20,0 сая төгрөгийн өртөг бүхий 5-р багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлын тендерт ганцаараа үнийн санал ирүүлсэн Боргүвээ иргэдийн бүлэг нь шаардлага хангахгүй учир дараагийн компанитай шууд гэрээ байгуулах зөвлөмжийг Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв гэж ажлын хэсгийн хурлын тэмдэглэлд бичсэн боловч ажил гүйцэтгэх гэрээг Боргүвээ иргэдийн бүлэгтэй байгуулж, уг бүлгийн ахлагчаар Талхун арал компанийн захирал Ч.Наранцогт ажилласан зэргээр бичиг баримтууд нь хоорондоо зөрчилдөж байна.*

Дээрх зөрчлүүдээс гадна Сүхбаатар суманд эрх шилжсэн 40,0 сая төгрөгийн өртөг бүхий “Гэрэлт цогцолборын засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр Сэлэнгэ Таванхан компанийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан боловч 6 сарын 21-нд тус компаниар 20,0 сая төгрөгийн өртөг бүхий 6 дугаар багийн хүүхдийн тоглоомын талбайн ажил, 20,0 сая төгрөгийн өртөг бүхий 7 дугаар багийн хүүхдийн тоглоомын талбай байгуулах

ажлыг гүйцэтгүүлэхээр, өөрөөр хэлбэл 1 компанийг цаг хугацааны хувьд давхацсан 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, гэрээ байгуулснаар Гэрэлт цогцолборын засварын ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрч гэрээний хугацааг сунгасан бөгөөд энэ нь хийгдсэн ажлууд чанарын шаардлага хангахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

2.11 Сүхбаатар, Хушаат, Шаамар сумдын ЗДТГ буюу захиалагч нь ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, үнэлгээний тайлан, тендерт оролцогч аж ахуйн нэгжийн ирүүлсэн тендерийн баримт бичиг зэргийг төсөл, арга хэмжээ тус бүрээр архивлаж, хадгалаагүй байгаа нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 49.1⁷ дэх заалтыг зөрчсөн байна.

2.12 Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018 оны 1-р сарын 15-ны өдрийн 15 дугаар бүхий албан бичгээр ТБОНӨХБАУХА тухай хуулийн 49.5, Сангийн сайдын 2012 оны 264 дугаар тушаалаар батлагдсан *“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”*-ын 3.1 дэх заалтуудын дагуу тайлант оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авалтын тайланг маягтын дагуу бэлтгэж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Б.3 Төсөл арга хэмжээний 58,8 хувийг нь хэрэгжүүлэх эрхийг сумд болон байгууллагуудад шилжүүлсэн нь худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулахгүй байх зөрчлийн үндсэн шалтгаан болж байна.

3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 50,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Сүхбаатар сумын 2 болон 4 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах”*, 46,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Мандал сумын 4-р сургуульд зөөврийн компьютер, принтер, тоног төхөөрөмж авах”* 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Сангийн сайдын 2017 оны 07-р сарын 05-ны өдрийн 240 дүгээр албан бичгээр, 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Мандал, Ерөө сумын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын цахилгаан хангамж”* төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Эрчим хүчний сайдын 2017 оны 09-р сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаалаар тус тус аймгийн Засаг даргад шилжүүлсэн боловч тушаалууд цахимаар хугацаа хоцорч ирсэнээс шалтгаалан төсвийн жилд хэрэгжүүлээгүй, зөвхөн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

3.2 ТБОНӨХБАУХА тухай хуулийн 45.6-д *“Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно”* гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2017 оны 05-р сарын 12-ны өдрийн А/221 дугаар захирамжаар 38 төсөл, арга хэмжээ, 2017 оны 11-р сарын 30-ны өдрийн А/487 дугаар захирамжаар 2 төсөл, арга хэмжээ, нийт 40 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг сумдын Засаг дарга нарт шилжүүлсэн байна. /Хавсралт 6-д харуулав /

3.3 Аймгийн Засаг даргын 11-р сарын 30-ны өдрийн А/487 дугаар захирамжаар 17.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Шаамар суманд зөгийн өвөлжөө байгуулах”*, 7.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй *“Цагааннуур сумын трансформатор засвар”*-ын зэрэг 2

⁷ Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтас хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.

төсөл, арга хэмжээний эрхийг тайлант жил дуусахаас ганцхан сарын өмнө, хүйтний улиралд шилжүүлсэн байгаа нь худалдан авах ажиллагаа оройтож зохион байгуулагдах, улмаар төсөл, арга хэмжээ гэрээт хугацаандаа ашиглалтад орохгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

3.4 Аудитын дүнгээс харахад худалдан авах ажиллагааг зохион байгуулах мэргэжлийн байгууллага болох ОНӨГ үйл ажиллагаа явуулж байхад тайлант онд орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 68 төсөл, арга хэмжээний 40-ийг нь буюу 58,8 хувийг нь хэрэгжүүлэх эрхийг сумд болон байгууллагуудад шилжүүлсэн нь үнийн санал авах мэдэгдэл хүргүүлэхгүй байх, ирүүлсэн тендерийг үнэлгээний хуудсаар үнэлэхгүй байх, шаардлага хангахгүй хуулийн этгээдийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулах, улмаар худалдан авах ажиллагааг огт зохион байгуулахгүйгээр шууд худалдан авах зэрэг зөрчлүүд гарах үндсэн шалтгаан болж байна.

3.5 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа зориулалтыг өөрчлөөгүй байна.

В.1 Төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд ашиглалтад оруулаагүй байхад гэрээний дагуу алданги тооцоогүй байна.

1.1 Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэхээр батлагдсан 17 төсөл, арга хэмжээнээс 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан нь бүрэн хэрэгжсэн байна.

1.2 Дээрх 14 төсөл, арга хэмжээний 8-ыг нь гэрээний хугацаанаас 6-97 хоногоор хэтрүүлж хүлээлгэн өгсөн байхад захиалагчийн зүгээс гүйцэтгэгчид хугацаа хэтрүүлсэн нийт 12,1 сая төгрөгийн алданги тооцоогүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7 /сая.төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч аж ахуйн нэгж	Гэрээний үнэ	Эхлэх дуусах хугацаа	Хүлээн авсан актын дугаар, огноо	Хугацаа хэтэрсэн хоног	Тооцвол зохих алданги
1	Ерөө сумын ЭМТ-ийн засвар, А.Б блокийн дээврийн засвар	“Талхун арал” ХХК	50.5	2017.05.08 2017.06.02	2017.06.08 №04	6	0.15
2	Сайхан сумын Номгон тосгоны ЭМТ-ийн засвар	“Ремугс” ХХК	50.0	2017.05.01 2017.05.30	2017.07.05 №08	35	0.88
3	Сүхбаатар сумын 2-р сургуулийн урлагийн заалны засвар	“Уран төмөр хэлхээ” ХХК	14.8	2017.06.02 2017.07.03	2017.07.21 №06	18	0.13
4	Сэлэнгийн долгио чуулгын барилгын дээвэр, гадна фасад засвар	“Чингисийн төгөл” ХХК	85.1	2017.06.02 2017.07.31	2017.09.11 №08	41	1.74
5	Аймгийн Спортын ордоны дээврийн засвар	“Ахмед интернейшнл моторс” ХХК	80.2	2017.06.02 2017.07.03	2017.11.07 №07	97	3.89
6	Сайхан сумын Соёлын ордоны дээврийн засвар	“Оюут гол” ХХК	104.6	2017.06.30 2017.10.10	2017.12.07 №25/2017	57	2.98
7	Сүхбаатар сумын багийн төвийн засвар, тохижилт	“Уран төмөр хэлхээ” ХХК	48.3	2017.06.30 2017.08.10	2017.11.01 №15/2017	80	2.38

8	Мандал сумын ЭМНД-ын тасгийн барилгын засвар	“Сэлэнгэ таванхан” ХХК	13.0	2017.08.29 2017.09.29	2017.11.30 №34/2017	61	0.40
	Нийт дүн		446.5				12.1

1.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 70 төсөл, арга хэмжээнээс 68 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан нь бүрэн хэрэгжсэн байна.

1.4 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс аймаг хэрэгжүүлсэн 9, сумдад эрх шилжүүлсэн 24 зэрэг нийт 33 төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанаас 3-163 хоногоор хэтрүүлж хүлээлгэн өгсөн байхад захиалагч болох аймаг, сумдын ЗДТГ-аас гүйцэтгэгчтэй гэрээний дагуу алданги тооцоогүйгээс нийт 20,7 сая төгрөгийг хэмнэх нөөц боломжийг алдсан байна. /Хавсралт 7-д харуулав /

Эдгээр нь нь төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан алданги тооцох хувь хэмжээг зөрчсөн байна.

1.5 Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, өмнөх оноос шилжиж ирсэн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Баянгол сумын Хүүхэд хөгжлийн ордны барилгын үлдэгдэл санхүүжилт” төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын 2017 оны 11-р сарын 14-ний өдрийн 33 дугаар тогтоолоор “Баянгол сумын шинэ соёлын төвийн зураг төсвийн үнэ” гэж өөрчилж, баталсан нь төсвийн жилд хэрэгжээгүй байна.

1.6 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар суманд уурын зуухны яндан буулгах” төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг урьдчилан тооцолгүйгээр төлөвлөсөн нь батлагдсан төсөвт өртгөөр гүйцэтгэх боломжгүй байдалд хүрч, хэрэгжээгүй байна.

В.2 Төсөл, арга хэмжээг хүлээн авсан комиссын акт болон ажлын гүйцэтгэлийн баримт, материал дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлсэн 14 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч компаниудад гэрээний дагуу 1,232.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан 68 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч 66 аж ахуйн нэгжид 1,613.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2.3 Аймгийн ИТХ-ын 2017 оны 21 дүгээр тогтоолоор Хөтөлийн “Цемент шохой” ХК-ийн ХХОАТ-ын авлагаас Замын сангийн хөрөнгө оруулалтын ажлыг гэрээгээр гүйцэтгэж буй аж ахуйн нэгжүүдэд 428.6 сая төгрөгийн цемент олгуулж, хөрөнгө оруулалтын санхүүжилтэд шилжүүлэн тооцохоор баталсны дагуу аймгийн Татварын хэлтэс нь “Цемент шохой” ХК-тай 2017 оны 04-р сарын 25-ны өдөр хамтран ажиллах ХАГ/2017/54 дугаартай гэрээ байгуулсан байна.

Гэвч дээрх тогтоолыг зөрчин орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих, хэрэгжилтэд нь цемент шаардлагагүй “Аймгийн Татварын хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах” төсөл, арга хэмжээний 25,0 сая төгрөгийн санхүүжилтийг цемент авч борлуулсан аж ахуйн нэгжээс гүйцэтгэгч “Хөтөл Төвхөн” ХХК-д шууд олгуулж, санхүүжилтийн гүйцэтгэлд төрөөс ямар ч хяналт хийгдээгүй байна.

Мөн 9.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хилийн цэргийн 101 дүгээр ангийн засвар”-ын ажлын санхүүжилтэд Цемент шохой компаниас цемент олгуулсан байна.

2.4 Сумдын хувьд захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсгээр хянан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, зураг төсвийн болон хяналт хэрэгжүүлэхээр захиалагчтай байгуулсан гэрээ зэрэг шаардлагатай баримт материалын бүрдэл дутуу төсөл, арга хэмжээнд нийт 48,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнд:

- ❖ 8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орхонтуул сумын халаалтын зуухны засвар”,
- ❖ 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цагааннуур сумын сургуулийн гал тогоонд тоног төхөөрөмж авах”
- ❖ 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орхонтуул сумын Рашаант тосгоны 2 дугаар сургуулийн тоног төхөөрөмж шинэчлэлт” зэрэг болно.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.5.7⁸, 4.5.9⁹ дэх заалтуудыг зөрчсөн байна.

2.5 Сүхбаатар суманд эрх шилжүүлсэн 2.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хог хураамжийн бүртгэл, тооцооны програм авах” төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан комиссын акт гараагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байгаа нь дээрх журмын 4.5.10¹⁰ дахь заалтыг зөрчсөн байна.

В.3 Барилга угсралт, их засварын ажлаас бусад болон шууд худалдан авах аргаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хийгдэхгүй байна.

3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлсэн, худалдан авах ажиллагааг НТШ-аар зохион байгуулсан 6, харьцуулалтын аргаар зохион байгуулсан 8 зэрэг нийт 14 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийхээс 13 төсөл, арга хэмжээний явцын болон техникийн хяналтыг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ гүйцэтгэсэн байна.

3.2 Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн 35,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хушаат сумын ЗДТГ-т автомашин авах” төсөл, арга хэмжээнд захиалагчийн зүгээс хяналт хийгээгүй байна.

⁸ Захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан, баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл.

⁹ ТЭЗҮ, зураг төсөв, техник хяналт, зөвлөх үйлчилгээний гэрээ.

¹⁰ Барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан тухай комиссын акт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт.

3.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлсэн 68 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийхээс худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулсан 29 төсөл, арга хэмжээний явцын болон техникийн хяналтыг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ гүйцэтгэсэн байна. /Хавсралт 8-д харуулав /

3.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлсэн, худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулсан 487,6 сая төгрөгийн өртөг бүхий 18 төсөл, арга хэмжээнд захиалагчийн зүгээс хяналт хийгээгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8

Д/д	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг /сая.төг/	Гүйцэтгэгч аж ахуйн нэгж
1	Зүүнбүрэн сумын сургуульд мэдээлэл зүйн кабинет байгуулах	20.0	Мөнхийн баярт од ХХК
2	Орхонтуул сумын Рашаант тосгоны 2-р сургуулийн тоног төхөөрөмж шинэчлэлт	26.6	Визарт экспресс консалтинг ХХК
3	Түшиг сумын эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	20.0	УАЗ МЕГА ХХК
4	Орхонтуул сумын Рашаант тосгоны эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	20.0	Санни Гоулд Хаус ХХК
5	Цагааннуур сумын сургуулийн гал тогоонд тоног төхөөрөмж авах	20.0	Мэйжүрмент ХХК
6	Жавхлант сумын Соёлын төвд хөгжим хэрэгсэл, тоног төхөөрөмж авах	29.1	Оюут гол ХХК
7	Худалдааны төвд агааржуулалт, кондейшн тавих	13.0	Сэлэнгэ хүрээлэн буй орчин ХХК
8	Шаамар суманд зөгийн өвөлжөө байгуулах	17.6	Ханлигтайшир ХХК
9	Хилийн цэргийн 0243-р ангид моторт завь худалдан авах	25.0	Шар нарст ХХК
10	Усан спортын төвд хүүхдийн сургалтын зам худалдан авах	18.0	Монтир транс ХХК
11	Сэлэнгийн долгио чуулгад тайзны гэрэлтүүлэг авах	47.3	Хараат богд ХХК
12	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт автомашин авах	18.0	Нарт оргил өргөө ХХК
13	Сүхбаатар суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах	50.0	Нарт оргил өргөө ХХК
14	Аймагт зөөврийн тайз, гэрэлтүүлэг авах	20.0	Буянт мөрөн арвижих ХХК
15	Сүхбаатар сумын 4-р багт ухаалаг худгийн тоног төхөөрөмж суурилуулах	48.0	Эйч ти эл ХХК
16	Аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарт Ipad худалдан авах	57.0	Нэкст дистрибьюшн ХХК
17	Аймгийн Татварын хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах	25.0	Хөтөл төвхөн ХХК
18	Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ-ын мах хадгалах зоорины хөргөлтийн тоног төхөөрөмжийн засвар, шинэчлэлт	13.0	Таван хан уул ХХК
	Нийт дүн	487,6	

3.5 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, шууд худалдан авах аргаар гүйцэтгүүлсэн 21 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн зүгээс хяналт хийгээгүй, гэрээний биелэлт, үр дүнг үнэлж, дүгнээгүй байна.

3.6 Бид аудитын явцад Мандал, Баянгол, Ерөө, Жавхлант, Хүдэр, Сүхбаатар, Шаамар зэрэг сумдад хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг газар дээр нь тулган

баталгаажуулахад 2017 онд улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бүрэн санхүүжилт олгосон бүх ажлуудыг ашиглалтад хүлээн авсан байсан бөгөөд ашиглагч байгууллагын зүгээс ямар нэгэн гомдол, санал гараагүй болно.



/Жавхлант сумын Соёлын төвийн хөгжим хэрэгсэл, тоног төхөөрөмж /



/Сүхбаатар сумын Шарын 11,12,13 байрны дунд тоглоомын талбай /

3.7 Харин ашиглалтад хүлээн аваад нэг жил ч болоогүй байхад Сүхбаатар сумын 7-р багийн хүүхдийн тоглоомын талбайн сагсны 1 талын самбар хагарч, хүрээ эвдэрсэн, Цагаан эрэг цогцолборын төмөр хашаа болон бетонон баганы тосон будаг, эмульс халцарч, өнгө үзэмж нь муудсан, засвар хийсэн эсэх нь мэдэгдэхээргүй байдалтай болсон байлаа. Цаашид орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн нийтийн эзэмшлийн тоглоомын талбай болон цогцолборын хөрөнгө оруулалтын ажлуудад ашиглаж, хэрэглэсэн түүхий эд материал, тоног төхөөрөмжийн чанарын байдалд захиалагчийн зүгээс тавих хяналт шалгалтын үр нөлөөг тогтмол сайжруулж байх нь зүйтэй юм.



Цагаан эрэг цогцолбор



7-р багийн тоглоомын талбай

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ❖ Зураг, төсвийг урьдчилан хийгээгүй 764,2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, батлуулсан,
- ❖ Сүхбаатар болон бусад 12 сум нь эрх шилжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэх хуудас хүргүүлээгүй 274,0 сая төгрөг / *Сүхбаатар 40,0 сая, бусад сумд 234,0 сая* /
- ❖ Сүхбаатар сумын худалдан авах ажиллагааны “Ажлын хэсэг” нь 235,0 сая төгрөгийн өртөг бүхий 18 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хуудсаар үнэлж, баримтжуулаагүй,
- ❖ Сүхбаатар сум нь 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “*Сүхбаатар сумын 7-р баг төмөр замын байруудыг хэрэглээний халуун усаар хангах зорилгоор зуух угсрах*”, 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “*Сүхбаатар сумын 7-р багийн дулаан хуваарилах төвийн засвар*”-ын ажлын гүйцэтгэгчээр тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан “Эко партнерс” ХХК-ийг сонгон шалгаруулсан,
- ❖ Сумдад эрх шилжүүлсэн 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримт материалын бүрдэл дутуу байхад 48.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон,
- ❖ Ашиглалтад хүлээлгэн өгөх гэрээний хугацааг хэтрүүлсэн гүйцэтгэгчид гэрээний дагуу 32,3 сая төгрөгийн алданги тооцоогүй,
- ❖ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 487,6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тоног, төхөөрөмж, машин техник худалдан авалтын гүйцэтгэлийг хяналтын хуудсаар баталгаажуулаагүй,
- ❖ Татварын хэлтсийн 25,0 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Цемент шохой компанийн ХХОАТ-ын өрөнд цемент авч борлуулсан хувийн компаниар дамжуулан гүйцэтгүүлснийг нотлох баримт байхгүй, гүйцэтгэлд хяналт тавьж, баримт, материал бүрдүүлээгүй,
- ❖ Сүхбаатар суманд эрх шилжүүлсэн “*Хог хураамжийн бүртгэл, тооцооны програм авах*” төсөл, арга хэмжээг хүлээн авсан комиссын акт гараагүй байхад 2,4 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон,
- ❖ Шууд худалдан авах босго үнээс давсан төсөвт өртөг бүхий Шаамар суманд зөөврийн тайз, хөгжим худалдан авах ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар бус шууд худалдан авах аргаар хэрэгжүүлсэн 20,0 сая төгрөг зэрэг **нийт 1,988.5** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага бичигдлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулж, мөрдөөгүй байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилга угсралт, их засвар зэрэг бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийг бус жижиглэсэн төсөл, арга хэмжээг түлхүү байдлаар тусгаж баталсан нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.
- Ажил хийгдсэний дараа санхүүжилтийг нь төлөвлөснөөс шалтгаалан худалдан авах ажиллагааны баримтуудыг төсөв батлагдсан хугацаанд нь тохируулан хуурамчаар бүрдүүлж байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулалтын шинж чанартай бус тухайн байгууллагын урсгал зардалд тусган, хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж байна.
- Багцалж болох төсөл арга хэмжээг, задалж, жижигрүүлэн төлөвлөн, хэрэгжүүлж байна.
- ТЭЗҮ, зураг, төсөв иж бүрэн хийгдээгүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж байна.
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах мэргэжлийн байгууллага болох ОНӨГ үйл ажиллагаа явуулж байхад тайлант онд орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 68 төсөл, арга хэмжээний 40-ийг нь буюу 58,8 хувийг нь хэрэгжүүлэх эрхийг сумд болон байгууллагуудад шилжүүлсэн нь үнийн санал авах мэдэгдэл хүргүүлэхгүй байх, үнэлгээний хуудсаар үнэлэхгүй байх, шаардлага хангахгүй хуулийн этгээдийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулах, улмаар худалдан авах ажиллагааг огт зохион байгуулахгүйгээр шууд худалдан авах зэрэг зөрчлүүд гарах үндсэн шалтгаан болж байна.
- Улсын төсөвт байгууллагуудад хийгдэх төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж байна.
- Аймгийн ОНӨГ-ын харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бүх “Ажлын хэсэг”-ийн даргаар 1 хүнийг, гишүүдээр 2 хүнийг гэх мэтчилэн тус газрын 3 мэргэжилтэнг тогтмол томилон ажиллуулж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг дагуулж байна.
- Сумдууд худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэл хүргүүлэхгүй байна.
- Сумдууд зарим төсөл, арга хэмжээний тендерийн баримт, материалыг үнэлгээний хуудсаар үнэлж, баталгаажуулаагүй байна.
- Худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулсан төсөл, арга хэмжээнд нэг ч үнийн санал ирээгүй, ирүүлсэн тендер шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр 60,7 хувийг нь шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсэн байна.
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчлөөгүй бөгөөд эрх шилжүүлэхдээ хугацаа алдсан байна.
- Төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд ашиглалтад оруулаагүй байхад гэрээний дагуу алданги тооцоогүй байна.
- Төсөл, арга хэмжээг хүлээн авсан комиссын акт болон ажлын гүйцэтгэлийн баримт, материал дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.
- Барилга угсралт, их засварын ажлаас бусад төсөл, арга хэмжээ болон шууд худалдан авсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хийгдэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ш.Оргил- д:

- Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, урт болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж мөрдөх.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тухайн байгууллагын урсгал зардалд суулгаж болох жижиглэсэн ажил, арга хэмжээг бус барилга угсралт, их засвар зэрэг бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийг тусгаж, хэрэгжүүлэх.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд улсын төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах зардлыг тусгахгүй байх.
- Ижил төстэй төсөл, арга хэмжээг нэгтгэн багцалж төлөвлөж, хэрэгжүүлэх.
- ТЭЗҮ, зураг, төсөв иж бүрэн хийгдсэн төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж байх.
- Төсвийн хөрөнгө оруулалтыг төсвийн тодотголоор төлөвлөж буй зөрчлийг арилгаж, хэрэгцээ, шаардлага, хөрөнгийн эх үүсвэрийг бодитоор тооцсоны үндсэн дээр хуулиар тогтоосон хугацаанд төлөвлөж, батлуулах.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний, ялангуяа ихээхэн хэмжээний өртөг бүхий төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн ОНӨГ-аар зохион байгуулуулах чиглэл барих.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, худалдан авах үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа-д:


- Худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулах “ Ажлын хэсэг”-ийг аймгийн ОНӨГ-ын 3-хан хүний явцуу хүрээнд бус 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр, захиалагч болох аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар байгуулж байх.
- Үнэлгээний хороо, Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, худалдан авах үйл ажиллагаанд оршиж буй зөрчлийг таслан зогсоох.
- Барилга угсралт, их засварын ажлаас бусад худалдан авалтууд болон шууд худалдан авсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх.
- Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж, гэрээний дагуу хугацаа хэтрүүлсэн хоног тутам алданги тооцох.

Аймгийн ОНӨГ-ын дарга П.Эрдэнэсайхан болон эрх шилжсэн төсөл арга, хэмжээг хэрэгжүүлж буй сумдын Засаг дарга нарт:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг чанартай сайн гүйцэтгэж байсан, шаардлага хангасан хуулийн этгээдүүдийн судалгаа, нэгдсэн сантай болох ажлыг зохион байгуулах.

- Худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа шаардлага хангасан 3 болон түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэл хүргүүлэх.
- Худалдан авах ажиллагааны тендерийн үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, баримтжуулдаггүй зөрчлийг таслан зогсоох.
- Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, хэн нэгэн албан тушаалтны санал болгосон гэдэг үндэслэлээр гүйцэтгэгчийг шалгаруулж, батлагдсан төсөвт өртгөөр нь шууд гэрээ байгуулж буй зөрчлийг арилгах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
С.БААСАНСҮРЭН
Ж.ЦОГТ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/04

Сүхбаатар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН,
ДҮНГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаалын 5-р хавсралт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40, 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторт Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөрчил арилгуулах албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн Засаг дарга Ш.Оргил, ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа, Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайхан, Сүхбаатар сумын Засаг дарга Т.Гантулга нарт хүргүүлж, Selenge@audit.gov.mn цахим хуудсаар нийтэд мэдээлсүгэй.
4. Аудитын тайланд тусгагдсан албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Батмөнх/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

0000793

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын
2018 оны 06 сарын 26 өдрийн
А/бч дугаар тушаалын хавсралт

/ сая төгрөгөөр /

43171439JP

№	Төлбөр, зөрчлийн утга	Албан шаардлагын дугаар	Нийт зөрчил	Албан шаардлага
1	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг, төсвийг урьдчилан хийгээгүй төсөл, арга хэмжээг тусгаж, батлуулсан, эрх шилжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэх хуудас хүргүүлээгүй, гүйцэтгэлийн баримт материалын бүрдэл дутуу байхад санхүүжилт олгосон, тоног төхөөрөмж, машин техник хэрэгсэл худалдан авалтын гүйцэтгэлийг тоног төхөөрөмжийн хяналтын хүснэгтээр баталгаажуулаагүй, аймгийн Татварын хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Цемент шохой компанийн ХХОАТ-ын ерөнд цемент авч борлуулсан хувийн компаниар дамжуулан гүйцэтгүүлснийг нотлох баримт байхгүй, гүйцэтгэлд хяналт тавьж, баримт, материал бүрдүүлээгүй, 20,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Шаамар суманд зөөврийн тайз, хөгжим худалдан авах ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалгүйгээр шууд худалдан авах аргаар хэрэгжүүлсэн, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээлгэн өгөх гэрээний хугацааг хэтрүүлсэн гүйцэтгэгчид гэрээний дагуу алданги тооцоогүй байна.	СЭА-01/01-ГА	1,611.1	1,611.1
2	Сүхбаатар сум нь эрх шилжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хуудсаар үнэлж, баримтжуулаагүй, 40,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэх мэдэгдэх хуудас хүргүүлээгүй, 100,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан "Эко партнерс" ХХК-ийг сонгон шалгаруулсан, 2,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Хог хураамжийн бүртгэл, тооцооны програм авах" төсөл, арга хэмжээг хүлээн авсан комиссын акт гараагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон зэрэг нийт 377.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ.	СЭЛ-02/02-ГА	377.4	377.4
Нийт дүн			1,988.5	1,988.5

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд
санхүүжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний жагсаалт**

/сая.төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	2017 онд санхүүжих дүн
Шилжих хөрөнгө оруулалт				
1	Баянгол сумын шинэ соёлын төвийн зураг төсвийн үнэ	2016-2017	20.0	20.0
2	Зүүнбүрэн сумын сургуульд мэдээлэл зүйн кабинет байгуулах	2016-2017	20.0	20.0
3	Сүхбаатар сумын барилгын 27-р байрыг хэрэглээний халуун усны шугамд холбох	2016-2017	20.0	20.0
4	Шаамар сумын шинэ цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулж, хашаа барих	2016-2017	27.0	27.0
5	Шаамар сумын Дулаанхаан тосгонд явган хүний зам барих	2016-2017	7.0	7.0
6	Орхонтуул сумын Рашаант тосгоны 2-р сургуулийн тоног, төхөөрөмж шинэчлэлт	2016-2017	26.6	26.6
7	Сант сумын сургуулийн зааланд тоног төхөөрөмж авах	2016-2017	20.0	20.0
8	Сайхан суманд ус зөөлрүүлэх төхөөрөмж авах	2016-2017	26.8	26.8
9	Түшиг сумын эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	2016-2017	20.0	20.0
10	Орхонтуул сумын Рашаант тосгоны эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	2016-2017	20.0	20.0
11	Цагааннуур сумын сургуулийн гал тогоонд тоног, төхөөрөмж авах	2016-2017	20.0	20.0
12	Жавхлант сумын соёлын төвд хөгжим хэрэгсэл, тоног төхөөрөмж авах	2016-2017	29.1	29.1
13	Алтанбулаг сумын 64 айлын нийтийн орон сууцны дотор санхтехник засвар	2016-2017	20.0	20.0
14	Баруунбүрэн сумын сургуулийн дотуур байрны барилгын засвар	2016-2017	20.0	20.0
15	Орхонтуул сумын халаалтын зуухны засвар	2016-2017	8.0	8.0
16	Хил хамгаалах туслах хүчний зөвлөлд сансрын холбооны антенн авах	2016-2017	8.4	3.3
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт				
17	Жавхлант суманд цэнгэлдэх хүрээлэн барих	2017-2017	80.0	80.0
18	Жавхлант суманд морь барианы талбай байгуулах	2017-2017	10.0	10.0
19	Хушаат суманд цэнгэлдэх хүрээлэн барих	2017-2017	80.0	80.0
20	Хушаат суманд морь барианы талбай байгуулах	2017-2017	10.0	10.0
21	Сүхбаатар сумын 3-н замын уулзвар, атарчдын дурсгалын хөшөө босгох	2017-2017	50.0	50.0
22	Цэнхэрийн 19,20-р байрны гадна тохижилт, зам өргөтгөх	2017-2017	40.0	40.0
23	Шаамар сумын 18-р цэцэрлэгийн хашаа барих	2017-2017	20.0	20.0
24	Сүхбаатар сумын 7-р баг төмөр замын байруудыг хэрэглээний халуун усаар хангах зорилгоор зуух угсрах	2017-2017	80.0	80.0
25	Сүхбаатар сумын 7-р багийн дулаан хуваарьлах төвийн засвар	2017-2017	20.0	20.0
26	Дулаанхаан тосгоны Захирагчийн албаны барилгын зураг төсвийн үнэ	2017-2017	10.0	10.0
27	Худалдааны төвийн агааржуулалт, кондейшн тавих	2017-2017	13.0	13.0

28	Сүхбаатар суманд уурын зуухны яндан буулгах	2017-2017	3.0	3.0
29	Шаамар суманд зөгийн өвөлжөө байгуулах	2017-2017	17.7	17.7
Тоног төхөөрөмж				
30	Хилийн цэргийн 0243-р ангид моторт завь худалдан авах	2017-2017	25.0	25.0
31	Усан спортын төвд хүүхдийн сургалтын зам худалдан авах	2017-2017	18.0	18.0
32	Аймгийн нэгдсэн эмнэлэгт тоног, төхөөрөмж авах	2017-2017	9.8	9.8
33	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны уулзалтын өрөөг тохижуулах	2017-2017	5.0	5.0
34	Сэлэнгийн долгио чуулгад тайзны гэрэлтүүлэн авах	2017-2017	47.3	47.3
35	Хүнс, хөдөө аж ахуйн газарт автомашин авах	2017-2017	18.0	18.0
36	Сүхбаатар сумын 4-р цэцэрлэгт зөөлөн эдлэл авах	2017-2017	5.0	5.0
37	Сүхбаатар суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах	2017-2017	50.0	50.0
38	Аймагт зөөврийн тайз, гэрэлтүүлэг авах	2017-2017	20.0	20.0
39	Сүхбаатар сумын 1-р сургуулийн гал тогооны тоног, төхөөрөмжийн шинэчлэл	2017-2017	6.0	6.0
40	Сүхбаатар сумын 5-р сургуулийн уурын зуухны тогоо шинэчлэх	2017-2017	7.0	7.0
41	Орхонтуул сумын Засаг дарга автомашин авах	2017-2017	30.0	30.0
42	Сүхбаатар сумын 4-н багт ухаалаг худгийн тоног төхөөрөмж суурилуулах	2017-2017	48.0	48.0
43	ИТХ-ын хурлын төлөөлөгч нарт iPad худалдан авах	2017-2017	57.0	57.0
44	Сүхбаатар суманд хогийн пункер авах	2017-2017	6.0	6.0
45	Аймгийн Прокурорын газарт архивын шүүгээ авах	2017-2017	4.8	4.8
46	Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт тоног, төхөөрөмж худалдан авах	2017-2017	10.0	10.0
47	Сүхбаатар суманд хог хураамжийн бүртгэл, тооцооны программ авах	2017-2017	2.4	2.4
48	Татварын хэлтэст тоног, төхөөрөмж авах	2017-2017	25.0	25.0
Их засвар				
49	Биеийн тамир спортын газрын барилгын их засвар	2017-2017	50.0	50.0
50	Аймгийн нэгдсэн эмнэлэгт засвар, автомашины засвар	2017-2017	27.1	27.1
51	Сайхан сумын Засаг даргын Тамгын газрын барилгын дээврийн их засвар	2017-2017	73.9	73.9
52	Гэрэлт хөшөөний засварын ажил, гэрэлтүүлэг, нийтийн бие засах газар барих	2017-2017	40.0	40.0
53	Цагаан эрэг цогцолборын засвар	2017-2017	8.0	8.0
54	Баруунбүрэн сумын эмнэлгийн засвар	2017-2017	30.0	30.0
55	Сүхбаатар самбарын засвар	2017-2017	5.0	5.0
56	Сүхбаатар сумын 5-р багт тоглоомын талбай байгуулах	2017-2017	20.0	20.0
57	Сүхбаатар сумын шарын 11,12,13-р байрны дунд тоглоомын талбай байгуулах	2017-2017	20.0	20.0
58	Сүхбаатар сумын 4-р сургуулийн спорт заалны засвар	2017-2017	30.0	30.0
59	Сүхбаатар сумын 1-р сургуулийн дотуур байрны засвар	2017-2017	20.0	20.0
60	Сүхбаатар сумын Спорт сургуулийн сантехник засвар	2017-2017	20.0	20.0
61	Алтанбулаг гаалийн шалган нэвтрүүлэх байрны нийтийн бие засах өрөөний тохижилт /орох, гарах/	2017-2017	40.0	40.0
62	Статистикийн хэлтсийн автомашины засвар	2017-2017	2.0	2.0
63	Сэлэнгийн долгио чуулгын гадна треас өргөтгөх	2017-2017	35.0	35.0
64	Хушаат сумын сургуулийн дээвэр засвар	2017-2017	9.0	9.0
65	Сүхбаатар сумын 7-р багийн 60 айлуудын дунд тоглоомын талбай байгуулах	2017-2017	20.0	20.0

